



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ДОЛОО ДУГААР ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ**

2025 оны 05 сарын 07 өдөр

Дугаар 29

Мөрөн сум

**Орон нутгийн хамгаалалтанд
авах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.18 дахь заалт, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3 дахь заалт, Байгаль орчны яамны сайдын 2000 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 07 тоот тушаалын "Газар нутгийг орон нутгийн хамгаалалтанд авах тухай" журмыг тус тус үндэслэн Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Долоодугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Хэнтий аймгийн Мөрөн сумын Бүрээт багийн нутагт байрлах "Дэлгэр уул, Хатан уул" нэртэй газрыг орон нутгийн хамгаалалтанд авахаар шийдвэрлэсүгэй.
2. Орон нутгийн хамгаалалтанд авах газрын байршил хэмжээг нэгдүгээр хавсралт, талбайн зураглалыг хоёрдугаар хавсралт, хамгаалалтын горимыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Орон нутгийн хамгаалалтанд авсан газрын холбогдох материалыг Ашигт малтмал газрын тосны газрын кадастрын хэлтэст хүргүүлэхийг Сумын Засаг Дарга (Н. Хатанбаатар)-д даалгасугай.
4. Энэхүү тогтоол батлагдан гарсантай холбогдуулан 2025 оны 04 дүгээр сарын 04-ны өдрийн Зургаадугаар хуралдааны 21-р тогтоолыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



Ж.ДАШЖАМЦ

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн
Долоодугаар хуралдааны ...-р
тогтоолын нэгдүгээр хавсралт




МӨРӨН СУМЫН ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТАД АВАХ
ГАЗРЫН БАЙРШИЛ ХЭМЖЭЭ

ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТАНД АВСАН ГАЗРЫН НЭР		БУЛАНГИЙН ЦЭГИЙН СОЛБИЦЛУУД							Зорилго	Талбайн хэмжээ / га /	Хугацаа /жил/
1	Дэлгэр уул, Хатан уул	1	47	24	25.0	110	24	20.0	Байгалийн Нөөц газар	1293.66	25
		2	47	23	0.0	110	24	20.0			
		3	47	23	0.0	110	21	27.10			
		4	47	23	15.29	110	21	30.99			
		5	47	23	15.80	110	21	22.22			
		6	47	23	19.77	110	21	23.39			
		7	47	23	20.09	110	21	19.85			
		8	47	23	16.27	110	21	14.30			
		9	47	23	15.88	110	21	20.85			
		10	47	23	16.63	110	21	8.01			
		11	47	23	16.54	110	21	6.42			
		12	47	23	13.45	110	21	3.03			
		13	47	23	8.46	110	21	1.96			
		14	47	23	0.0	110	21	14.90			
		15	47	23	0.0	110	20	20.0			
		16	47	24	25.0	110	20	20.0			
		17	47	24	25.0	110	24	20.0			

Сумын ИТХ-ын 2025 оны 05 дугаар сарын 07-ны
өдрийн Долоодугаар хуралдааны 29-р тогтоолын
Хоёрдугаар хавсралт



МӨРӨН СУМЫН ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТАД АВАХ ГАЗРЫН ХИЛИЙН ЦЭСИЙН ТОЙМ ЗУРАГ





Хамгаалалтад авсан газарт хэрэгжүүлэх
Үйл ажиллагааны горим

Нэг. Зорилго

Монгол Улсын холбогдох хууль тогтоомжуудын хүрээнд Байгаль орчны сайдын 2000 оны 07 тоот тушаалаар баталсан “Газар нутгийг орон нутгийн хамгаалалтад авах тухай” журам, “Орон нутгийн онцгой ач холбогдол бүхий газар нутгийг тусгай хамгаалалтад авч тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөх” зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор **Дэлгэр уул, Хатан уул** нэртэй газрыг байгалийн экологийн тэнцвэр хадгалах, нөөц баялаг, бэлчээрийн хамгаалалт, ашиглалттай холбогдсон аливаа үйл ажиллагааг зохицуулахад оршино.

Хоёр. Ерөнхий зүйл

2.1 Орон нутгийн хамгаалалттай газар гэж тухайн нутгийн унаган төрх, өвөрмөц тогтоц, түүх соёлын дурсгал, амралт, аялал жуулчлалын ач холбогдол бүхий болон доройтсон газрыг хамгаалах, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах зорилгоор хамгаалалтад авсан газрыг хэлнэ.

2.2 **Дэлгэр уул, Хатан уул** нэртэй газар нутгийн байгалийн бүх төрлийн баялаг төрийн зохицуулалтад байна.

2.3 Хамгаалалтад авсан газар нутагт ашигт малтмалын онцгой ач холбогдолтой хуримтлал байгаа нь судалгаагаар илэрч түүнийг улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн эрх ашгийн үүднээс зайлшгүй ашиглах шаардлагатай нь мэргэжлийн шинжээчдийн дүгнэлтээр нотлогдсон тохиолдолд ашигт малтмалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр сумын ИТХ тухайн газар нутгийг хамгаалалтаас бүрэн буюу хэсэгчлэн чөлөөлж болно.

2.4 **Дэлгэр уул, Хатан уул** нэртэй газар нутгийн хамгаалалттай холбогдсон үйл ажиллагааг Монгол Улсын Тусгай хамгаалттай газрын дүрэм, энэ горимын дагуу хариуцна.

2.5 Холбогдох сумын Засаг даргын тамгын газар нь газрыг хамгаалахад өмчийн бүх төрөлд хамаарах аж ахуйн нэгж, байгууллага иргэдийг идэвхтэй оролцуулах үүрэг хүлээнэ.

2.6 Байгаль хамгаалагчийг томилон, мэрэгжлийн удирдлага, техник хэрэгслээр хангаж, ажил үүргийнх нь биелэлтэд аймгийн Байгаль орчны газарт тавьж ажиллана.

2.7 Ургамал амьтны өсч үржих, таатай нөхцлийг хангах, хөрсийг нөхөн сэргээх, байгалийн гамшгаас учирсан хохирлыг арилгах зэрэг байгаль орчныг хамгаалах арга хэмжээ авна.

Гурав. Хамгаалалттай газарт зөвшөөрөх үйл ажиллагаа

3.1 Сумын Засаг даргын тамгын газраас Тусгай хамгаалалттай газрын дүрэмд заасан арга хэмжээг **Дэлгэр уул, Хатан уул** нэртэй газрын Байгалийн экологийн тэнцвэр хадгалах газарт дор дурьдсан үйл ажиллагааг явуулна.

3.2 **Дэлгэр уул, Хатан уул** нэртэй газарт судалгаа хийх

3.3 Шаардлагатай тохиолдолд байгаль орчин болон газрын төлөв байдлыг алдагдуулахгүйгээр мал бэлчээх

3.4 **Дэлгэр уул, Хатан уул** нэртэй газарт иргэн, аж ахуйн нэгж, байгууллага мод бут тарих, ургамалжуулах

Дөрөв. Хамгаалалттай газарт хориглох үйл ажиллагаа

4.1 Орон нутгийн хамгаалалттай газарт дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно

4.2 Зөвшөөрөлгүйгээр үйлдвэрлэлийн зориулалтаар загас барих, ан амьтан агнах, тэднийг үргээн дайжуулах

4.3 Ургамлан нөмрөг талхлах, хөрс, ус, агаар бохирдуулах

4.4 **Дэлгэр уул, Хатан уул** нэртэй газар нутагт түймэр гаргах

4.5 Хортон шавьж, мэрэгчид, түймэртэй тэмцэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэхэд байгаль орчинд сөргөөр нөлөөлөх арга техник, бодис хэрэглэх

4.6 Шинээр ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын ажил явуулах

Тав. Хамгаалалттай газрын санхүүжилт

5.1 Аймаг, сумын төсвөөс хуваарилж болох хөрөнгө

5.2 Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад гэрээгээр эзэмшүүлсний төлбөр болон хандив тусламж

Зургаа. Тавих хяналт, тайлагнах

6.1 Холбогдох сумын Засаг даргын тамгын газраас сумын хамгаалалттай газарт энэ горимын дагуу үйл ажиллагааг явуулж, уг горимыг зөрчсөн гэм буруутай этгээдэд байгаль орчны бүх шатны байцаагчид эрх хэмжээнийхээ хүрээнд Улсын тусгай хамгаалалттай газрын дүрэм, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавина.

6.2 Хамгаалалтанд авсан газарт хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаар тухайн орон нутгийн Байгаль орчны улсын хяналтын байцаагч жил бүрийн 12 дугаар сарын 10-нд аймгийн Засаг даргад тайлагнана.